



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 860

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 7.2 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэт үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хавсралтад заасан 245,130,825.00 (хоёр зуун дөчин таван сая нэг зуун гучин мянга найман зуун хорин таван) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий 2 ширхэг тээврийн хэрэгслийг ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож Орхон-А33А” төрийн өмчит хувьцаат компанийд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал Х.Бадамсүрэн, “Орхон-А33А” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ц.Батзориг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн шинэчлэн тогтоосон үнэ, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусгах;

2.3. Тээврийн хэрэгслийн улсын дугаарыг улсын бүртгэл, татвар төлөгчөөс бүртгэлээс хасаж шилжүүлсэн тодорхойлолт, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 137 дугаар тогтоолын хавсралтын 8,9 дэх мөрийг хүчингүйд тооцсугай.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001282

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 09 дугаар сарын 01. өдрийн
66.0 дугаар тогтоолын хавсралт

"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРГЭЛТЭЙ
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСАЛТ

Д/Д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ, /хууримтлагдсан эпэгдэл/ төгрөг	Шилжүүлэн авах хуулийн этгээд	Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг)	Ашиглаж хугацаа (жил)
1	Хынчдай Стариикс, суудлын 39-84 оро арап КМАУА37НАВИ317791	2011	42,964,575.00	"Орхон АЗЗА" ТӨХК	3,000,000.00	1
2	Трубоукладчик ТР 12, 19, 02 наб №623	2007	202,166,250.00		2,500,000.00	1
			245,130,825.00		5,500,000.00	
	Нийт дүн		(хоёр зуун дөчин таван сая нэг зуун гучин мянга найман зуун хорин тав)		(таван сая таван зуун мянга)	